



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА  
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Манхан сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ХОА-2025/008/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a>	Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар Цахим хаяг: Boldbaatar.Kh@audit.gov.mn Аудитын менежер: А.Цэцэгсүрэн Утас: 70432545
Ховд хот	Цахим хаяг: tsetsegsuren.a@audit.gov.mn
2025 он	Аудитор: Д.Энхжаргал Утас: 99434344 Цахим хаяг: Enkhjargald@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлангай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ .....	5
2.1 Аудит хийсэн нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан.....	5
2.2 Аудит хийсэн нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	5
2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан	Error! Bookmark not defined.
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	Error! Bookmark not defined.
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	7
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА .....	Error! Bookmark not defined.
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа .....	Error! Bookmark not defined.
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	Error! Bookmark not defined.
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд.	Error! Bookmark not defined.
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .....	Error! Bookmark not defined.
4. АУДИТЫН ТАЙЛАН .....	Error! Bookmark not defined.
4.1 Ерөнхий зүйл .....	Error! Bookmark not defined.
4.2 Материаллаг байдал .....	Error! Bookmark not defined.
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт .....	Error! Bookmark not defined.
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт...	Error! Bookmark not defined.
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....	8
АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	10

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
УТХО	Улсын төсвийн хөрөнгө оруулалт
ИГХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ТБОНӨХБАҮХА	Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах



**ХОВД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд  
Утас: 976-70433061, Факс: 976-70433061  
E-mail: khovd@audit.gov.mn

2025.03.25 № 2/119  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

МАНХАН СУМЫН ТӨСВИЙН  
ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧ  
П.МЯГМАРСҮРЭН ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Ховд аймгийн Манхан сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Татварын болон татварын бус орлогоор нийт 873,987.2 мянган төгрөгийн орлого бүрдүүлж төлөвлөгөөг 180,329.5 мянган төгрөг буюу 26 хувиар давуулан биелүүлсэн байна.

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Материаллаг буруу эрсдэлийн үнэлгээ өндөр анхаарал татах асуудал гараагүй болно.

**Бусад асуудлын хэсэг**

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ХҮНДЭТГЭСЭН:

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Х.БОЛДБААТАР

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан

(мян.төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2023оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	515,234.6	728,081.7
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	197,313.6	374,822.0
33	АВЛАГА	232,300.2	230,984.3
34	УРЬДЧИЛГАА	34,000.0	0.0
35	БАРАА МАТЕРИАЛ	43,620.8	87,275.4
36	НӨӨЦИЙН БАРАА	8,000.0	35,000.0
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	5,511,997.0	6,004,050.5
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	5,511,997.0	6,004,050.5
39200	Биет хөрөнгө	5,419,469.0	5,911,528.7
39300	Биет бус хөрөнгө	92,528.0	92,521.8
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	6,027,231.6	6,732,132.2
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	1,883.7	2,234.9
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,883.7	2,234.9
41300	Өглөг	1,883.7	2,234.9
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	6,025,347.9	6,729,897.3
51	Засгийн газрын хувь оролцоо	6,025,347.9	6,729,897.3
51100	Засгийн газрын оруулсан капитал	974,241.4	974,241.4
51200	Хуримтлагдсан үр дүн	4,059,030.2	4,766,988.3
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	992,076.4	988,667.6
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	6,027,231.6	6,732,132.2

### 2.2 Аудит хийсэн нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

(мян.төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2023оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	6,052,765.1	4,021,296.8
11	ТАТВАРЫН ОРЛОГО	428,937.9	784,877.9
110	Орлогын албан татвар	301,273.2	651,746.8
1100	Хувь хүний орлогын албан татвар	329,220.6	689,289.4
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-27,947.4	-37,542.6
113	Хөрөнгийн албан татвар	70,922.9	88,415.9
118	Бусад татвар, төлбөр, хураамж	56,741.7	44,715.2
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,546,214.4	1,144,276.1
120	Нийтлэг татварын бус орлого	1,546,214.4	1,144,276.1
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	4,077,612.8	2,092,142.9
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	4,779,833.9	3,312,168.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,779,833.9	3,312,168.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,305,618.6	3,272,461.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	607,220.4	979,328.6
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	74,446.3	119,264.1
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	694,675.2	768,867.1
2104	Хангамж, бараа материалын зардал	557,958.0	800,806.8
2105	Нормативт зардал	520.0	531.6
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,466.9	9,310.3
2107	Томиллолт, зочны зардал	6,369.4	8,738.0

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	965,324.8	29,733.6
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	394,637.5	555,881.2
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,474,215.4	39,707.3
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	1,272,931.1	709,128.2
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	1,272,931.1	709,128.2

### 2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	4,673,396.4	3,055,226.9
11	ТАТВАРЫН ОРЛОГО	428,937.9	784,877.9
110	Орлогын албан татвар	301,273.2	651,746.8
1100	Хувь хүний орлогын албан татвар	329,220.6	689,289.4
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-27,947.4	-37,542.6
113	Хөрөнгийн албан татвар	70,922.9	88,415.9
118	Бусад татвар, төлбөр, хураамж	56,741.7	44,715.2
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	15,759.1	6,841.1
1181	Газрын төлбөр	22,381.8	23,186.4
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	18,600.9	14,687.6
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	152,673.5	167,999.0
120	Нийтлэг татварын бус орлого	152,673.5	167,999.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	4,091,785.0	2,102,350.0
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,976,764.0	2,094,120.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,976,764.0	2,094,120.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,494,229.3	2,054,412.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	604,323.2	964,598.4
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	73,491.5	120,949.6
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	694,675.2	774,841.0
2104	Хангамж, бараа материалын зардал	33,765.1	30,502.6
2105	Нормативт зардал	652.5	703.7
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,294.4	11,068.9
2107	Томилолт, зочны зардал	6,369.4	8,738.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	964,869.8	48,662.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	110,788.1	94,348.7
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,482,534.8	39,707.3
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	696,632.3	961,106.8
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	560,288.0	733,448.4
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	560,288.0	733,448.4
2200	Дотоод эх үүсвэрээр	560,288.0	733,448.4
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-560,288.0	-733,448.4
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-140,100.0	-50,150.0
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	140,100.0	50,150.0
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	-3,755.7	177,508.4
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	201,069.3	197,313.6

20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	197,313.6	374,822.0
----	---	-----------	-----------

#### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

(мян.төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,764,348.4	4,764,348.4
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	4,764,348.4	4,764,348.4
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-11,931.6	-11,931.6
9	Тайлант үеийн үр дүн	1,272,931.1	1,272,931.1
10	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	6,025,347.9	6,025,347.9
11	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	6,025,347.9	6,025,347.9
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-1,170.0	-1,170.0
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	6,024,177.9	6,024,177.9
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-3,408.8	-3,408.8
19	Тайлант үеийн үр дүн	709,128.2	709,128.2
20	2024 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	6,729,897.3	6,729,897.3

#### 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

(мян.төгрөгөөр)

Код	Тайлангийн үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,996,573.70	2,862,720.86
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,097,062.20	2,080,287.04
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,056,278.70	2,040,579.76
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	974,582.90	964,598.39
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	121,823.00	120,949.64
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	777,081.40	773,921.65
2104	Хангамж, бараа материалын зардал	29,674.80	29,592.40
2105	Нормативт зардал	703.7	703.7
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	11,068.90	11,068.90
2107	Томилолт, зочны зардал	9,571.50	8,738.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	48,190.80	47,425.38
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	83,581.70	83,581.70
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	40,783.50	39,707.28
2132	Бусад урсгал шилжүүлэг	40,783.50	39,707.28
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	835,282.00	732,283.82
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	64,229.50	50,150.0
3	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,996,573.70	2,956,509.04
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,762,541.20	2,877,619.70
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	234,032.50	78,889.34
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	74,346.88
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0	168,135.06
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	89	89
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	3	3
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	43	43
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	43	43

#### 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

(мян.төгрөгөөр)

Код	Тайлангийн үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,118,778.02	33,466.47
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,118,778.02	33,466.47
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,110,458.63	14,997.63
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	545,259.23	919.3
2104	Хангамж, бараа материалын зардал	0	910.15
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	530974.96	1,236.60
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	34,224.44	11,931.58
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	8,319.39	18,468.84
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	8,319.39	18,468.84
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,118,778.01	33,466.47
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,118,778.01	33,466.47

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар ХХСан, ОНХС, ТТЗ-тай холбоотой нийт 104,817.4 мянган төгрөгийн алдаа<sup>1</sup> зөрчил илэрснээс аудитын явцад 10,059.8 мянган төгрөгийн алдааг залруулав. Үүнд:

- Авлагын дэлгэрэнгүй бүртгэлээрх үндсэн зээлийн авлага, хүүгийн авлага нь байдлын тайланд хоорондоо зөрүүтэй илэрхийлсэн 9,617.4 мянга, зээлийн хүүг дутуу тооцсон 442.4 мянган төгрөгөөр.

Залруулагдаагүй нийт 94,757.6 мянган төгрөгийн зөрчлийн 16,932.9 мянган төгрөг нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс бага байгаа тул "Өөрчлөлтгүй" дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 94,757.6 мянган төгрөгийн зөрчил<sup>2</sup> илэрснээс 94,757.6 мянган төгрөгийн 4 заалт бүхий зөвлөмж бичлээ.

### 5.1 Төлбөрийн акт тогтоогоогүй

### 5.2 Зөвлөмж

#### 5.2.1 Орон нутаг хөгжүүлэх сантай холбоотой асуудал

**Илрүүлэлт:** "Эмэгтэйчүүдийн хөгжлийг дэмжих дэд хөтөлбөр", "Гамшгаас хамгаалах зардал", "Шинэ замын кадастр зураг хийлгэх", "Бэлчээрийн мониторинг газрын төлөвлөлт хяналтын зардал", "Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардал", "Нохой устгал", Хүний нөөцийн хөгжил, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр", "Баян тохой гудамжинд гэрэлтүүлэг хийх", "Газрын албанд түргэн скайнер авах", "Сайрын худгийн оролцоо", "Цаг уурын автомат дэлгэц авах" зэрэг ажлууд багийн иргэдийн олонхын саналаар дэмжигдэж эрэмбэлэгдээгүй байгаа нь Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар батлагдсан Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журмын 4.3.2 "ОНХС-н хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нь тухайн орон нутгийн иргэдийн саналаар дэмжигдэж эрэмбэлэгдсэн байх" гэсэн заалттай нийцэхгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** ОНХС-ийн үйл ажиллагааны журмыг баримтлан төлөвлөлт хийж, гүйцэтгэл хангуулж ажиллах

#### 5.2.2 Орон нутаг хөгжүүлэх сантай холбоотой асуудал

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнаа хандсан /мартсан/, тэмдэглээгүй орхисон/.

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

**Илрүүлэлт:** ОНХС-ийн хөрөнгөөр "Малжуулах хөтөлбөр"-өөр олгосон хугацаа хэтэрсэн насжилт өндөртэй авлага барагдаагүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-т "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;" Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.5-т "хуваарьт болон хугацаа хэтэрсэн өр төлбөрийг жилийн төсөвтөө бүрэн тусгаж өр төлбөр барагдуулах төлөвлөгөө, хуваарь баталж хэрэгжүүлэх" гэсэн заалттай нийцэхгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** "Малжуулах хөтөлбөр"-өөр олгосон зээлийн авлагыг шүүхэд хандан барагдуулах арга хэмжээ авах

### **5.2.3 Хоршоо хөгжүүлэх сантай холбоотой асуудал:**

**Илрүүлэлт:** Хугацаа дууссан зээлдэгчийн авлагыг Шүүхэд хандаж шийдвэр гаргуулаагүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2-т "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", 41 дүгээр зүйлийн 41.2.7-т "хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, хүрэх үр дүнг хангаж ажиллах", зээлдэгч нартай байгуулсан гэрээний холбогдох заалттай нийцэхгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг батлуулах саналыг сумын ИТХ-д оруулахдаа зориулалт болон хүчин чадал, нэршил, байршил нь ижил арга хэмжээг нийт дүнгээр нь батлуулан хуулийн хүрээнд худалдан авах ажиллагаа зохион байгуулж байх.

### **5.2.4 Татварын орлоготой холбоотой асуудлаар**

**Илрүүлэлт:** Харин түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр 4,000.0 мянга, газрын төлбөр 12,932.9 мянган төгрөгөөр тасарсан байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 6.2.2.-т "жил бүрийн төсвийн зарлагыг орлого болон санхүүжүүлэх бусад эх үүсвэрээр нь бүрэн нөхдөг байхаар төлөвлөн баталж, хэрэгжүүлэх", 6.2.3-т "урьдчилан тооцоолох боломжгүй нөхцөл байдлын улмаас төсвийн орлого буурах, эсхүл зарлага нэмэгдсэнээр төсвийн алдагдал нэмэгдэхээр бол төсвийн зарлагыг бууруулах, эсхүл орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэх замаар тухайн жилийн төсөвт тодотгол хийж, төсвийг тэнцвэржүүлэх", 41.2.1-т "хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх" гэсэн заалттай нийцэхгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Татварын орлогыг нэр төрлөөр бодитой төлөвлөж, биелэлтийг хангуулах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 07 дүгээр сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

6.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Мянган төгрөгөөр

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдааны утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Залруулсан		Залруулаагүй		Зөвлөмж	
		Нийт алдаа		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14
ХХС	Авлагын дэлгэрэнгүй бүртгэлээрх үндсэн зээлийн авлага, хүүгийн авлага нь байдлын тайланд хоорондоо зөрүүтэй татагдсан, зээлийн хүүг дутуу тооцсон	1	10,059.8			1	10,059.8	1	10,059.8				
	<b>ДҮН</b>	<b>1</b>	<b>10,059.8</b>			<b>1</b>	<b>10,059.8</b>	<b>1</b>	<b>10,059.8</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>

6.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Мянган төгрөгөөр

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн	
		Нийт алдаа, зөрчлийн дүн		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
ОНХС	Батийн иргэдийн олонхын саналаар дэмжигдэж эрэмбэлэгдээгүй ажил санхүүжүүлсэн	1	0					1	0		
ХХС	"Малжуулах хөтөлбөр"-өөр олгосон хугацаа хэтэрсэн насжилт өндөртэй зээлийн авлага барагдаагүй	1	29,325.1					1	29,325.1		
	Хугацаа дууссан зээлдэгчийн авлагыг Шүүхэд хандаж шийдвэр гаргуулаагүй байна	1	48,499.6					1	48,499.6		
ТТЗ	Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр 4,000.0 мянга, газрын төлбөр 12,932.9 мянган төгрөгөөр тасарсан байна.	1	16,932.9					1	16,932.9		
	<b>Нийт дүн</b>	<b>4</b>	<b>94,757.6</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>4</b>	<b>94,757.6</b>	<b>0</b>	<b>0</b>